# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр Дугаар 573 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн нийт 43,833,333.33 (дөчин гурван сая найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Түмэндэмбэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132001497

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 573 дугаар тогтоолын хавсралт

**"Булган-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ниссан навара маркийн автомашин, 54-58 БУЛ улсын дугаартай, арлын дугаар-LGAWAHAAH19660405 | 2004 | 1 | 14,500,000.00 | 14,500,000.00 |
| 2 | Прадо-120 маркийн, суудлын автомашин, 27-01 БУЛ улсын дугаартай, арлын дугаар-LGAWAHAAH19660406 | 2004 | 1 | 29,333,333.33 | 29,333,333.33 |
| | ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН | | 2 (хоёр) | | 43,833,333.33 (дөчин гурван сая найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг гучин гурван мөнгө) |